

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: Төрийн хяналт шалгалтын тухай хууль

Дагаж мөрдөх огноо: 2023.01.01

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан
огноо: 2024

Байгууллагын нэр:

Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газар

Нэгжийн нэр:

Хяналт шалгалтын хэлтэс

Албан тушаалын нэр:

Хяналт шалгалтын хэлтсийн дарга,
улсын ахлах байцаагч

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Дэс түшмэл, ТЗ-6

Ажлын цаг

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Дархан-Уул аймаг, Дархан сум 5-р баг,
Эрүүл мэндийн газар

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Эрүүл мэндийн салбарын холбогдох хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын биелэлтэд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх замаар болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн салбарын хяналт шалгалт, эрсдэлийн удирдлагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг хангах;
2. Хариуцсан нэгжийн улсын байцаагчдад мэргэжлийн арга зүйн дэмжлэг үзүүлэх, хариуцсан асуудлаарх салбар дундын хамтын ажиллагааны нэгдсэн удирдлага, зохицуулалт хийх;
3. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн нэгдсэн удирдлага зохицуулалт, хяналт, тайлагналтыг хариуцах;
4. Гамшиг, олныг хамарсан өвчлөл, онцгой байдлын үеийн хяналт шалгалтын удирдлага, төлөвлөлт, зохицуулалт хийх;
5. Улсын ахлах байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалт хийх, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах
6. Хэлтсийн үйл ажиллагааны зохион байгуулалт, зохицуулалтыг нэгдсэн удирдлагаар хангах
7. Холбогдох хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын дотоод ажилд оролцох, удирдлагаас хуулийн хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Гүйцэтгэх-Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	Орон нутгийн эрүүл мэндийн салбарын хяналт шалгалтын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, бодлого, хөгжлийн стратегийг тодорхойлох, бодлогын баримт бичигт тусгуулах, дунд хугацааны болон жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах	Салбарын хяналт шалгалтын ажлыг оновчтой төлөвлөн хэрэгжүүлж, үр дүнг дээшлүүлсэн байна.	Г, Х
	Эрүүл мэндийн салбарын хяналтын чиглэлээр батлагдсан эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр хяналт шалгалтын объектын эрсдэлийн үнэлгээ хийх, хяналтын хуудсыг шинэчлэхэд санал өгөх, хяналт шалгалтын мэдээллийг цахим системд бүртгэх, хяналт шалгалт хийх объектыг төлөвлөх, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах	Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг оновчтой хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна.	Г, Х, Ш
	Хяналт шалгалтын дүнд үндэслэн эрүүл мэндийн салбарын хяналтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох болон салбарын хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан шийдвэрлүүлэх	Хяналт шалгалт хийх эрх зүйн орчин боловсронгуй болсон байна	Г, Х, Ш
	Улсын (ахлах) байцаагчийн боловсруулсан хяналт шалгалтын баримт бичиг болон албан бичгийг	Стандартын шаардлагыг хангасан байна.	Х, Ш

	хянаж, хяналт шалгалтын үйл ажиллагаа, түүний гүйцэтгэлд үнэлэлт, дүгнэлт өгөх		
	Аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах мэдээлэл, зөвлөмжөөр хангах	Аж ахуйн нэгж байгууллагын хуулийн сахин мөрдөлт сайжирсан байна.	Г, Х, Ш
2 дугаар зорилтын хүрээнд	Хэлтсийн улсын (ахлах) байцаагчдын мэдлэг, ур чадварын түвшин, сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, түүнд тулгуурлан санал боловсруулж шийдвэрлүүлэх	Улсын байцаагчдын мэдлэг, ур чадвар, ажлын чадавх дээшилнэ.	Г, Х
	Байгууллагын сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу болон бусад арга хэлбэрээр улсын байцаагчдыг мэргэшүүлэх, давтан сургах сургалтад хамруулах		Г, Х
	Байгууллагын болон салбарын сургалт зохион байгуулах удирдамж, төлөвлөлт, арга зүй, хөтөлбөр, гарын авлага, зөвлөмж, мэдээллээр хангаж, үр дүнг тооцох		Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх, нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах	Нэгдсэн бүртгэл, мэдээллийн сантай болсон байна.	Г, Х, Ш
	Хариуцсан салбарын улсын (ахлах) байцаагчдын гаргасан хяналт шалгалтын баримт бичиг болон хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбогдуулан иргэн, ААНБ-аас ирсэн гомдлыг хянан шийдвэрлэх	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	Х, Ш
4 дүгээр зорилтын хүрээнд	Гамшиг, олныг хамарсан өвчлөл, онцгой байдлын үеийн хяналт шалгалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх, боловсронгуй болгох санал боловсруулж дээд байгууллагад хүргүүлэх	Онцгой байдлын үеийн хяналт шалгалтыг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажилласан байна.	Г,Х,Ш
	Гамшиг, олныг хамарсан өвчлөл, онцгой байдлын үеийн хяналт шалгалтын төлөвлөлт, хэрэгжилтийг орон нутгийн түвшинд зохион байгуулах		Г,Х,Ш
	Гамшиг, олныг хамарсан өвчлөл, онцгой байдлын үеийн хяналт шалгалтыг орон нутгийн түвшинд удирдлага, зохицуулалтаар хангах		Г,Х,Ш
5 дугаар зорилтын хүрээнд	Улсын ахлах байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалт хийх, шалгалтын ажлын хэсэгт ажиллах, хяналт шалгалтын баримт бичиг үйлдэх	Хяналт шалгалт бүрэн гүйцэт хийгдсэн байна.	Г



	Нэгжийн улсын байцаагчийн гаргасан акт, дүгнэлт, албан шаардлагыг хянах, улсын байцаагчийн үйл ажиллагаа болон хяналт шалгалттай холбогдуулан гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	Г, Х, Ш
	Улсын ахлах байцаагчийн бусад нийтлэг чиг үүрэг болон хууль тогтоомж, хэм хэмжээний актад заасан өдөр тутмын бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн байна.	Г, Х
	Холбогдох байгууллагатай тохиролцон зохих мэргэжлийн хүмүүсийг хяналт шалгалтын ажилд татан оролцуулах, шаардлагатай асуудлыг магадлах зорилгоор дээж авч итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулж, дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах	Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна.	Г, Х, Ш
	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зохих хууль, журмын дагуу хэрэгжүүлэх	Хууль, журмын дагуу хэрэгжүүлсэн байна.	Г, Ш
6 дугаар зорилтын хүрээнд	Нэгжийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах	Гүйцэтгэлийн үр дүн зохих журмын дагуу үнэлж, дүгнэгдсэн байна.	Г, Х, Ш
	Нэгжийн улсын байцаагчдын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах, гүйцэтгэлд хяналт тавих		Х, Ш
	Нэгжийн чиг үүрэг, үйл ажиллагааг өдөр тутмын удирдлага, зохион байгуулалтаар хангах	Ажлын зохион байгуулалт, төлөвлөлт, гүйцэтгэл хангагдсан байна	Г, Х
	Нэгжийн үйл ажиллагааны болон хяналт шалгалтын үр дүнг олон нийтэд мэдээлэх, сурталчлах	Олон нийтэд сурталчилсан байна.	Г, Х
	Нэгжийн албан хаагчдын боловсруулсан албан бичиг, тушаалын шийдвэрийн төслийг хянах, архив, албан хэрэг хөтлөлтөд хяналт тавих.	Албан хэргийг стандартын дагуу хөтөлсөн байна.	Г, Х
	Тайлан мэдээг цаг тухайд нь холбогдох газарт хүргүүлэх, чиг үүргийн холбогдолтой мэдээллээр шуурхай хангах ажлыг зохион байгуулах, хяналт тавих.	Мэдээллээр шуурхайн ханган ажилласан байна.	Г, Х
7 дугаар зорилтын хүрээнд	Хяналт шалгалтын үр дүнг олон нийтэд мэдээлэх, сурталчлах	Олон нийтэд сурталчилсан байна.	Г
	Холбогдох төрийн болон төрийн бус, олон нийтийн байгууллагатай хамтран	Хамтын ажиллагаа өргөжсөн байна.	Г



	ажиллах, гадаад, дотоодын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцох		
	Архив, албан хэрэг хөтлөлтийг зохих заавар, журмын дагуу хэрэгжүүлэх	Заавар, журам, стандартад нийцсэн байна.	Г
	Байгууллагын болон салбарын сургалтад хамрагдах, хариуцсан хяналтын чиглэлээр аж ахуйн нэгж байгууллагад сургалт зохион байгуулах	Улсын байцаагчдын мэдлэг, ур чадвар, ажлын чадавх дээшилнэ.	Г
	Удирдлага болон холбогдох байгууллагыг мэдээллээр хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх	Мэдээлэл, мэргэжил арга зүйн туслалцаа нь хууль тогтоомжид нийцсэн, үнэн зөв байна.	Г,Т
	Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх	Үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай гүйцэтгэж, эргэн тайлагнасан байна.	Г,Т
	Хууль, журамд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.	Шаардлагын түвшинд хэрэгжүүлсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй		
Мэргэжил	- Эрүүл ахуй, тархвар судлал /102101/, - Нийгмийн эрүүл мэнд /098801/, - Нийгмийн эрүүл мэнд судлалч /721100, 720100/, - Нийгмийн эрүүл мэнд судлалч, Эрүүл ахуйч /091801/, - Анагаах ухаан /0912/, - Уламжлалт анагаах ухаан /0917/		
Мэргэшил	-Төрийн албанд мэргэшүүлэх богино, дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх. -Тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх		
Туршлага	-Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно. -Улсын байцаагчаар 3-аас доошгүй жил ажилласан байх.		
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	- нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх, тайлагнах; - нэгжийн үйл ажиллагаа дахь эрсдэлийн нөхцөл байдлыг тодорхойлох, эрсдэлийг илрүүлэх, шинжлэх, дүгнэх, эрсдэлийн арга хэмжээний хувилбарыг боловсруулах, хяналт тавих; - нэгжийн албан хаагчдад ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, зөвлөх, чиглүүлэх; - албан хаагчдын санал, бодлыг сонсох, бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжих;	

		- үл ойлголцол, саналыг зөрүүг эв зүйгээр зохицуулах; - бусад.
Дүн шинжилгээ хийх		- мэдээлэлд тулгуурлан, бүтэц, чиг үүргийн болон салбарын системийн шинжилгээ хийх; - харьцуулсан судалгаа хийх, судалгааны үр дүнг үнэлэх, тайлбарлах; - шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх; - бодлогын үндэслэлтэй санал, дүгнэлт зөвлөмж боловсруулах; - бусад.
Асуудал шийдвэрлэх		- хуульд нийцсэн оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах; - аливаа харилцааг хэрэгжүүлэх арга замыг хууль тогтоомж шийдвэрийн төсөлд тусгах, санал боловсруулах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд аливаа асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах; - тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар тайлбарлах, зөвлөх; - бусад.
Манлайлах		- төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн зарчим, нийтлэг хэм хэмжээг сахин мөрдөж, ёс зүйн шаардлагыг биелүүлэх; - өөрийн мэдлэг, мэдээллээ хамт олонтой хуваалцах, түгээн дэлгэрүүлэх; - бусадтай хүндэтгэлтэй, адил тэгш, итгэл төрүүлэхүйц, ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - бусдын санал бодлыг анхааралтай сонсож санал санаачилгыг дэмждэг байх; - аливаа асуудлыг хамтын ажиллагаанд тулгуурлан шийдвэрлэдэг байх; - аливаа сөргөлдөөн, зөрчилдөөнийг эвээр зохицуулах; - бусад.
Бусад		- кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - Төрийн албаны үндсэн болон тусгай зарчмыг чанд мөрдөж, хариуцлага хүлээх чадвартай байх; - Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, түүнд орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг үнэн зөв мэдүүлэх; - мэдээллийн технологийг албан ажилдаа бүтээлчээр хэрэглэх; - албан бичгийг төрийн албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулах ур чадвартай байх; - ажлын цагийг бүрэн, үр бүтээлтэй ашигладаг байх; - бусад.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ



Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Эрүүл мэндийн газрын дарга.....

Албан тушаалд шууд харьяалан
удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Улсын (ахлах) байцаагчид

Бусад харилцах субъект:

- яам, агентлагийн холбогдох албан тушаалтан
- нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын холбогдох албан тушаалтан
- төрийн болон төрийн бус байгууллага
- иргэн, аж ахуйн нэгж, байгууллага

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолт
боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж,
батлах зөвшөөрөл олгосон байгууллагын
шийдвэр:

Албан тушаал:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 2024.08.21

Дугаар: 353

2024 оны 10 сарын 03-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Шийдвэрийн огноо:

Дугаар:

(тамга/тэмдэг)

ДАРГА:

2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр